



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 45 36,
Цахим шуудан: prd.institute@parliament.mn,
Цахим хуудас: www.research.parliament.mn

2026. 01. 27 № 1501/0027
танай 2026. 01. 08 -ны № УИХ-03/120-Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАЯРМАА ТАНАА

Танаас “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд зардлын тооцоо хийлгэхээр 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-03/120 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу холбогдох зардлын тооцоог хийж, тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 11 хуудастай.

Хувийг: Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд.

ЗАХИРАЛ



Д.БУМДАРЬ

1526030041



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааны төрөл: **Зардлын тооцоо**
Судалгааны код: **ЗТ-26/901**
Хугацаа: **2026-01-14**

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Ж.Баярмаа

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр (Ph.D)

Судалгаа удирдсан: Парламентын хөгжлийн хэлтсийн дарга П.Түмэнцэцэг

Судлаач: Парламентын хөгжлийн хэлтсийн референт
Б.Эрдэнэбаяр

Улаанбаатар хот
2026

Агуулга

Хүснэгтийн жагсаалт	3
Удиртгал	4
ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	5
1. Ерөнхий мэдээлэл.....	5
2. Хуулийн этгээдэд үүсэх зардал.....	8
3. Иргэний зардлыг тооцох	8
4. Төрийн байгууллагад үүсэх зардал, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл	8
ДҮГНЭЛТ	10
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	11

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Өөрчлөлт оруулж буй хуулийн төсөл.....	6
Хүснэгт 2. Сүүлийн 5 жилийн байдлаар хувь хүний орлогын албан татвараас төвлөрүүлсэн орлогын хэмжээ.....	9
Хүснэгт 3. Сүүлийн 5 жилийн байдлаар хувь хүний орлогын албан татварын хувийг 1% болгон бууруулбал төвлөрүүлсэн орлогын хэмжээ.....	9

Удиртгал

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, зардлын тооцоог Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргах зардлыг тооцох.

Судалгааны ажлын бүтэц: Хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, зардлын тооцоог дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Иргэнд үүсэх зардлын тооцоо;
2. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо;
3. Төрийн байгууллагын зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл.

Судалгааны арга зүй: Зардлын тооцооллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” (цаашид Аргачлал гэх)-ын дагуу гүйцэтгэсэн.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

1. Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно”, 18.1.1-т “хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;” 18.1.2-т “хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох;” гэж заасан байдаг. Энэ хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан боловсруулав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн² 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ.

Тус хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдаж, түүнээс хойш нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.³

Хууль санаачлагчаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.1-д заасны дагуу нийтийн өргөдлийн цахим системд иргэнээс гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ногддог албан татварын хэмжээг 1% болгож бууруулах өргөдөлд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 100,187 иргэн санал өгсөн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “ажил хөдөлмөр эрхэлдэг, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлэхийн тулд татвар, эдийн засгийн бодлоор дэмжих, дунд, бага орлоготой орлогыг нэмэгдүүлж, татварын ачааллыг бууруулна” гэх зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн.

Татварын бодлогын хувьд Монгол Улс өнөөдрийг хүртэл төсвийн зарлагыг санхүүжүүлэх татварын бодлого хэрэгжүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд төсвийн зарлагыг санхүүжүүлэх зорилгоор төсвийн орлогыг өндрөөр төсөөлж тэр нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн хувьд ихээхэн дарамт болж байна. 2015 онд 6.1 их наяд орчим байсан улсын төсвийн орлого 2025 онд 33.5 их наядаар батлагдаж, энэ хугацаанд 5.58 дахин өссөн байна. Гэтэл 2015 онд

¹ Хууль тогтоомжийн тухай хууль (§18 дугаар зүйл). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2019). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14410>

³ Тус хуульд 2020 (1 удаа), 2022, 2023 (2 удаа), 2025 онд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

680.7 мянган төгрөг байсан голч цалин 2025 оны эхээр 2,229.4 мянган төгрөгт хүрч 3.27 дахин өссөн байна.

2024 оноос нийслэл хотын албан татвар 100%, цахилгаан эрчим хүчний үнэ 30% буюу түүнээс дээш, 2025 оноос автотээврийн хэрэгслийн албан татвар 200%, нийслэлийн автозам ашигласны төлбөр 400%, автотээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр 100% тус тус нэмэгдсэн. Дулаан болон усны нэмэгдсэн үнэ тариф 2026 оноос үйлчилж эхлэнэ. Үндэсний Статистикийн Хорооны 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр нийтэлсэн ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн судалгаагаар 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар НДШ төлсөн 787.4 мянган ажиллагчдын 50 хувь нь голч цалин болох 2 сая 229 мянган төгрөгөөс бага цалинтай байна.

Үндэсний Статистикийн хороо Дэлхийн банктэй хамтран 2024 оны 2 дугаар сард Монгол Улсын Ядуурлын түвшний үзүүлэлтүүдийг 2022 оны байдлаар танилцуулсан. 2022 он ядуурлын шугамын шинэ суурь он болсон. Ядуурлын шугам буюу нэг хүний нэг сарын хэрэглээ 2022 онд 418,045 төгрөг гэж тогтоогдсон. Насанд хүрсэн нэг хүнд ногдох хэрэглээний зардал нь ядуурлын шугамаас доогуур бол тухайн хүнийг ядуу гэж тодорхойлдог. 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1%-тай байгаа бөгөөд нийт 913.7 мянган хүн ядуу амьдарч байна. Ядуурлын шугамыг 15%-аар өсгөхөд хүн амын 10.3% буюу 346.8 мянган хүн ядууралд өртөхөд бэлэн байна.

Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн мэдээллээр 973,145 иргэн 1,981.4 тэрбум төгрөгийн татварын орлогыг цалингийн орлогоос, 96,532 иргэн 21.4 тэрбум төгрөгийн татварын орлогыг шууд бус орлогоос, 115,809 иргэн 79.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг үйл ажиллагааны орлогоос, 2,111,252 иргэн 341.6 тэрбум төгрөгийн татварын орлогыг хөрөнгийн орлогоос, 4,822 иргэн 23.0 тэрбум төгрөгийн татварын орлогыг хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогоос, 45,702 иргэн 2.6 тэрбум төгрөгийн татварын орлогыг бусад орлогоос тус тус 2024 онд улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Хувь хүний орлогын албан татварын орлогын 2024 оны дүнд цалингийн татвар 80.88 хувь, хөрөнгийн орлогын татвар 13.94 хувь, үйл ажиллагааны орлого 3.26 хувь, хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн орлого 0.93 хувь, шууд бус орлого 0.87 хувь, бусад орлого 0.1 хувь тус тус эзэлж байна.

Дээр дурдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилгууд, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, практик үндэслэл, шаардлагад үндэслэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэжээ.

Хүснэгт 1. Өөрчлөлт оруулж буй хуулийн төсөл

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн заалт	Өөрчлөлт оруулах хуулийн төсөл
<p>21 дүгээр зүйл. Албан татварын хувь, хэмжээ</p> <p>21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000</p>	<p>21 дүгээр зүйл. Албан татварын хувь, хэмжээ</p> <p>“21.1.Энэ хуулийн 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан тухайн жилийн орлогод 1 хувиар тооцон албан татвар ногдуулна.”</p>

<p>төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна.</p>	
<p>21.2.Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна:</p> <p>21.2.1.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;</p> <p>21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар;</p> <p>21.2.3.энэ хуулийн 19.1.2-т заасан орлогын дүнд 40 хувиар;</p> <p>21.2.4.энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар;</p> <p>21.2.5.энэ хуулийн 20.1, 20.4-т заасан орлогын дүнд 20 хувиар.</p>	<p>21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг: “21.2 энэ хуулийн 20.1, 20.4-т заасан орлогын дүнд 20 хувиар;”</p>
<p>21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:</p> <p>21.5. Энэ хуулийн 21.2.4, 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна.</p>	<p>21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:</p> <p>“Энэ хуулийн 21.1, 21.2-т заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 1 хувиар албан татвар ногдуулна.”</p>
<p>25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг</p> <p>25.7.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ.</p>	<p>25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг</p> <p>“25.7.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татварыг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ.”</p>
<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн заалт</p>	<p>Өөрчлөлт оруулах хуулийн төсөл</p>
	<p>2 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг,</p>

	26.1.5 дахь заалтын "21.2.2" гэснийг, 26.1.6 дахь заалтын "21.2.3" гэснийг тус тус "21.1" гэж, 25.1.6 дахь заалтын "21.2.5" гэснийг "21.2" гэж тус тус өөрчилсүгэй.
	3 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дахь хэсгийн "21.3," гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн "23.1" гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсгийн "23.1-д зааснаас бусад" гэснийг тус тус хассугай.
	4 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг, 28 дугаар зүйлийн 28.1.2-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
	Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Хуулийн этгээдэд үүсэх зардал

Аргачлалын хоёрдугаар хэсэгт хуулийн этгээдийн зардлыг тооцох арга замыг тодорхойлсон байдаг. Тус аргачлалын 2.3-т тухайн хуулийн этгээдийн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах үүрэг нэг бүрийг тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохоор заасан байна.

Харин Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн ямар нэгэн зохицуулалт агуулаагүй байна.

Иймд хуульд өөрчлөлт орсноор хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй.

3. Иргэний зардлыг тооцох

Аргачлалын гуравдугаар хэсэгт иргэний зардлыг тооцох арга замыг тодорхойлсон бөгөөд Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээнд өөрчлөлт орж байгаа учир иргэнд нэмэлт зардал болон ачаалал үүсэхгүй болно.

4. Төрийн байгууллагад үүсэх зардал, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл

Энэ хэсэгт аргачлалын дөрөвдүгээр хэсэгт төрийн байгууллагын зардал болон улсын төсөвт үүсэх ачааллыг тооцов.

Хуульд өөрчлөлт орсноор хувь хүний албан татвартай холбоотой Татварын ерөнхий газар болон нэгжүүдийн гүйцэтгэх үүрэгт шинээр өөрчлөлт ороогүй тул нэмэлт зардал үүсэхээргүй байна.

Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл

Монгол Улсын Хувь хүний орлогын албан татвар 2021 онд 1.15 их наяд төгрөг байсан бөгөөд 2022 онд 19%-иар, 2023 онд 22%-иар, 2024 онд 59%-иар, 2025 онд 12%-иар өсөж 2.97 их наяд төгрөг болж өссөн байна. 2021 оны Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 2025

оны хэмжээтэй харьцуулахад 2.5 дахин нэмэгджээ. Сүүлийн 5 жилийн байдлаар Хувь хүний орлогын албан татварын хэмжээ жилд дунджаар 28%-ийн өсөлттэй байна.

Хувь хүний орлогын албан татварыг бүрдүүлсэн орлогын ангиллаар авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нийт албан татварын 2021 онд 74.3%-ийг, 2022 онд 77.2%-ийг, 2023 онд 78.7%-ийг, 2024 онд 73.3%-ийг, 2025 онд 77.4%-ийг эзэлсэн байх бөгөөд дунджаар нийт татварын орлогын 76.2%-ийг бүрдүүлсэн байна.

Хөрөнгийн орлого нийт албан татварын 2021 онд 11.4%-ийг, 2022 онд 7.6%-ийг, 2023 онд 7.7%-ийг, 2024 онд 6.9%-ийг, 2025 онд 7.8%-ийг бүрдүүлсэн ба дунджаар 8.3%-ийг эзэлж байгаа бол шууд бус орлого 2021 онд 4.7%-ийг, 2022 онд 6.8%-ийг, 2023 онд 6.7%-ийг, 2024 онд 11%-ийг, 2025 онд 7.2%-ийг эзэлж, дунджаар 7.3%-ийг бүрдүүлжээ. Үлдсэн орлогууд нийт албан татварын дунджаар 8.3 хувийг эзэлсэн байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Сүүлийн 5 жилийн байдлаар хувь хүний орлогын албан татвараас төвлөрүүлсэн орлогын хэмжээ.

Тухайн жилд төвлөрсөн орлого:		2021	2022	2023	2024	2025
Хувь хүний орлогын албан татвар		1,147,283,772,524	1,362,765,435,625	1,657,431,794,000	2,630,406,033,174	2,965,053,680,838
1.1.1.1.	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	852,519,321,818	1,052,397,029,562	1,304,089,463,500	1,927,880,810,721	2,295,391,058,282
1.1.1.2.	Үйл ажиллагааны орлого	49,501,498,841	52,544,331,215	51,754,872,100	102,850,441,030	90,459,149,448
1.1.1.3.	Хөрөнгийн орлого	130,807,364,318	103,645,105,397	126,982,319,600	180,884,572,932	229,897,752,355
1.1.1.4.	Хөрөнгө борлуулсны орлого	60,724,994,161	61,738,470,315	63,878,866,800	125,047,943,028	131,293,486,227
1.1.1.5.	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцож олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого	-	-	-	-	-
1.1.1.6.	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	363,357,665	282,846,300	266,500,000	4,413,497,392	3,061,014,894
1.1.1.7.	Шууд бус орлого	53,367,235,722	92,157,652,836	110,459,772,000	289,328,768,071	214,951,219,633
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(32,777,427,401)	(51,137,076,513)	(63,566,885,900)	(78,897,501,470)	(90,541,158,064)
татварын орлогын өсөлт		32%	19%	22%	59%	12%

Эх сурвалж: Сангийн яам

Одоо мөрдөгдөж байгаа Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг 1% болгон бууруулан тооцвол дараах нөхцөл байдалтай байхаар байна.

Хүснэгт 3. Сүүлийн 5 жилийн байдлаар Хувь хүний орлогын албан татварын хувийг 1% болгон бууруулбал төвлөрүүлсэн орлогын хэмжээ.

Татварын хувь хэмжээг 1% болгосон тохиолдолд татварын орлого буурах тооцоолол:

		2021	2022	2023	2024	2025
Хувь хүний орлогын албан татвар		114,728,377,252	136,276,543,563	158,223,656,367	251,254,263,133	283,160,780,207
1.1.1.1.	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	85,251,932,182	105,239,702,956	123,476,610,231	182,539,767,477	217,337,165,097
1.1.1.2.	Үйл ажиллагааны орлого	4,950,149,884	5,254,433,121	5,175,487,210	10,285,044,103	9,045,914,945
1.1.1.3.	Хөрөнгийн орлого	13,080,736,432	10,364,510,540	12,698,231,960	18,088,457,293	22,989,775,235
1.1.1.4.	Хөрөнгө борлуулсны орлого	6,072,499,416	6,173,847,032	6,387,886,680	12,504,794,303	13,129,348,623
1.1.1.5.	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцож олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого	-	-	-	-	-
1.1.1.6.	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	36,335,766	28,284,630	26,650,000	441,349,739	306,101,489
1.1.1.7.	Шууд бус орлого	5,336,723,572	9,215,765,284	10,458,790,286	27,394,850,218	20,352,474,817
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(3,277,742,740)	(5,113,707,851)	(6,018,776,942)	(7,470,343,339)	(8,572,813,137)

Эх сурвалж: Сангийн яам

Сангийн яамны хийж ирүүлсэн тооцооллоор Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг 1% болгон бууруулбал татварын төвлөрүүлэх орлогын хэмжээ сүүлийн 5 жилийн дунджаар 10.2 дахин буурахаар байх бөгөөд 2025 оны байдлаар 283.2 тэрбум болж 10.4 дахин буюу огцом буурахаар байна. Монгол Улсын 2026 оны төсвийн хувьд Хувь хүний орлогын албан татвараас 2.98 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон байх бөгөөд хэрэв албан татварын хувь хэмжээг 1% болгон бууруулж, өмнөх онуудын дунджид хуваавал ойролцоогоор 291.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсөв 2.68 их наяд орчим төгрөгөөр багасахаар байна.

Зардлын тооцоо гаргах аргачлалын хүрээнд улсын төсөвт үзүүлэх зардлын тооцоог гаргахаар байгаа боловч боловсруулж буй хуулийн төслийн онцлогоос хамаарч орон нутгийн төсөвт шууд нөлөөлөл үзүүлэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8⁴ дахь хэсэгт 2020 оны 12 дугаар 24-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Хувь хүний орлогын албан татварын орлого нь сум, дүүргийн төсвийн татварын орлого байхаар хуульчилжээ. Хуулийн төслийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг бууруулснаар сум, дүүргийн төсөв огцом буурч, буурсан хэмжээгээр улсын төсвөөс нэмэлт санхүүжүүлэх хөрөнгийг гаргах шаардлага үүсэхээр байна.

ДҮГНЭЛТ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийв. Өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхээргүй байна. Харин сум, дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ буурч, улмаар улсын төсөвт давхар нөлөө үзүүлэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэгт зааснаар Хувь хүний орлогын албан татварын орлого нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн орлого байхаар хуульчилсан. 2026 онд Хувь хүний албан татвараас 2.97 их наяд төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон байх бөгөөд үүнийг 5 жилийн дундаж болох 10.2-т хуваавал ойролцоогоор 291.8 тэрбум орчим төгрөгийн татварын орлого сум дүүргийн төсвийн орлогод төвлөрч, 2.68 их наяд орчим төгрөгөөр багасахаар байна. Төсвийн орлогын дээрх зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлага үүснэ учир нь сум, дүүргийн төсвийн дийлэх хувийг Хувь хүний орлогын албан татварын орлогоос бүрдүүлдэг болно.

⁴ Төсвийн тухай хууль (§23 дугаар зүйл). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail/12254>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- *Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);*
- *Хууль тогтоомжийн тухай хууль (2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);*
- *Төсвийн тухай хууль (2012 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн)*
- *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”*